



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4 Аудитын илрүүлэлт	15
4.1 Төлбөрийн акт	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	16
1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠒᠒.᠐᠒.᠒᠘ № 53
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ У.ПУНЦАГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Уулбаян сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлж, тайлагнасан, хандивын орлогыг данс бүртгэлд тусгаагүй, эмийн орлогыг бөөн дүнгээр бүртгэсэн, хөрөнгө бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, өмнөх аудитын актын биелэлтийг биелүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,004,138.00</u>	<u>74,460,920.92</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	636,032.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	636,032.42
3121	Төгрөг	00.00	636,032.42
31211	Төрийн сангийн харилцах	00.00	504,032.42
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	132,000.00
33	АВЛАГА	00.00	45,158,400.00
335	Бусад авлага	00.00	45,158,400.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	45,158,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,004,138.00	28,666,488.50
351	Түүхий эд материал	10,475,998.00	12,180,358.50
35110	Тусгай зориулалттай материал	7,318,500.00	5,534,367.50
35130	Эм боох материал	3,157,498.00	6,645,991.00
354	Хангамжийн материал	15,963,140.00	15,821,130.00
35410	Бичиг хэргийн материал	655,000.00	655,000.00
35420	Аж ахуйн материал	12,680,450.00	13,321,950.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,193,500.00	275,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,030,000.00	1,030,000.00
35460	Хүнсний материал	404,190.00	539,180.00
35600	Мал амьтад	565,000.00	665,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>276,539,298.60</u>	<u>320,980,308.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	276,539,298.60	320,980,308.07
392	Биет хөрөнгө	267,757,298.60	312,198,308.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	231,248,513.33	266,248,513.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,326,413.96	-19,138,507.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,200,000.00	27,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,333,333.40	-15,866,666.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,758,553.64	115,224,411.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67,038,585.87	-72,113,472.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,391,296.50	12,391,296.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,091,531.68	-12,177,630.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,829,500.00	17,791,064.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,880,699.96	-7,360,699.92
393	Биет бус хөрөнгө	8,782,000.00	8,782,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,782,000.00	8,782,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>303,543,436.60</u>	<u>395,441,228.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>303,543,436.60</u>	<u>395,441,228.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	303,543,436.60	395,441,228.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	378,017,703.51	378,017,703.51
51101	Өмч: - төрийн	378,017,703.51	378,017,703.51
512	Хуримтлагдсан үр дүн	-90,726,339.45	1,171,452.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-90,726,339.45	-90,726,339.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	91,897,792.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,252,072.54	16,252,072.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>303,543,436.60</u>	<u>395,441,228.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	397,160,914.96	649,017,793.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,624,230.96	96,821,082.39
120	Нийтлэг татварын бус орлого	19,624,230.96	96,821,082.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,624,230.96	96,821,082.39
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,624,230.96	96,821,082.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	35,462,384.00	200,500,811.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	342,074,300.00	351,695,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,908,774.00	123,836,781.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,759,037.00	123,343,981.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,737.00	492,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,293,600.00	18,407,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,293,600.00	18,407,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,260,010.00	58,256,730.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,260,010.00	58,256,730.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	374,025,856.44	529,892,720.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,025,856.44	529,892,720.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,087,407.41	503,414,517.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,475,116.97	315,826,791.58
210101	Үндсэн цалин	160,617,964.04	207,495,624.93
210102	Нэмэгдэл	61,285,352.93	76,327,893.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,784,000.00
210104	Урамшуулал	20,571,800.00	28,219,273.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,345,400.00	43,400,473.00
210201	Тэтгэврийн даатгал	23,465,300.00	32,007,773.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,470,000.00	2,780,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,976,000.00	2,296,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	494,000.00	574,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,940,100.00	5,741,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,726,405.00	13,369,567.00
210301	Гэрэл, цахилгаан	3,183,964.00	3,336,509.00
210302	Түлш, халаалт	9,542,441.00	10,033,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,695,310.00	14,033,470.00
210401	Бичиг хэрэг	1,769,350.00	878,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,447,710.00	11,280,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,644,950.00	1,732,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,300.00	142,150.00
2105	Нормативт зардал	34,155,784.96	63,683,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,167,242.96	49,286,413.00
210502	Хоол, хүнс	6,584,463.00	14,397,312.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	404,079.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,389,137.00	6,345,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,320,037.00	2,985,300.00
210604	Урсгал засвар	2,069,100.00	3,360,650.00
2107	Томилолт, зочны зардал	120,000.00	195,000.00
210702	Дотоод албан томилолт	120,000.00	195,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	13,905,883.00	12,287,403.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,745,691.00	12,287,403.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	160,192.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,274,370.48	34,272,137.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,434,800.00	18,285,725.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,839,570.48	15,986,412.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,938,449.03	26,478,203.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,030,600.00	26,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,030,600.00	26,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,907,849.03	78,203.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,907,849.03	78,203.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>23,135,058.52</u>	<u>119,125,072.99</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	27,227,280.60
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	27,227,280.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-27,227,280.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>23,135,058.52</u>	<u>91,897,792.39</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,017,703.51	16,252,072.54	-113,861,397.97	280,408,378.08
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,135,058.52	23,135,056.52
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,017,703.51	16,252,072.54	-90,726,339.45	303,543,436.60
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	378,017,703.51	16,252,072.54	-90,726,339.45	303,543,436.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	378,017,703.51	16,252,072.54	-90,726,339.45	303,543,436.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	91,897,792.39	91,897,792.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,017,703.51	16,252,072.54	1,171,452.94	395,441,228.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>377,536,684.00</u>	<u>507,038,311.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,536,684.00	507,038,311.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	342,074,300.00	351,695,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,908,774.00	123,836,781.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,759,037.00	123,343,981.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,737.00	492,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,293,600.00	18,407,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,293,600.00	18,407,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,260,010.00	13,098,330.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,260,010.00	13,098,330.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>367,076,684.00</u>	<u>506,402,278.58</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,076,684.00	506,402,278.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,138,234.97	479,924,075.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,475,116.97	315,826,791.58
210101	Үндсэн цалин	160,617,964.04	207,495,624.93
210102	Нэмэгдэл	61,285,352.93	76,327,893.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,784,000.00
210104	Урамшуулал	20,571,800.00	28,219,273.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,345,400.00	43,400,473.00
210201	Тэтгэврийн даатгал	23,465,300.00	32,007,773.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,470,000.00	2,780,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,976,000.00	2,296,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	494,000.00	574,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,940,100.00	5,741,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,183,905.00	13,369,567.00
210301	Гэрэл, цахилгаан	3,183,964.00	3,336,509.00
210302	Түлш, халаалт	9,999,941.00	10,033,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,955,310.00	14,033,470.00
210401	Бичиг хэрэг	2,029,350.00	878,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,447,710.00	11,280,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,644,950.00	1,732,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,300.00	142,150.00
2105	Нормативт зардал	32,830,183.00	60,859,502.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,381,010.00	48,212,080.00
210502	Хоол, хүнс	6,180,273.00	12,647,422.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,268,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,318,137.00	5,696,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,249,037.00	736,800.00
210604	Урсгал засвар	2,069,100.00	4,959,530.00
2107	Томилолт, зочны зардал	120,000.00	195,000.00
210702	Дотоод албан томилолт	120,000.00	195,000.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,905,883.00	12,287,403.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,745,691.00	12,287,403.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	160,192.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,004,300.00	14,255,539.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,004,300.00	14,255,539.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,938,449.03	26,478,203.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,030,600.00	26,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,030,600.00	26,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,907,849.03	78,203.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,907,849.03	78,203.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,460,000.00	636,032.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,460,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,460,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,460,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,460,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,460,000.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	636,032.42
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	636,032.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	400,855,800.00	382,619,294.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	400,855,800.00	382,619,294.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,655,800.00	381,419,294.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,062,400.00	277,939,383.58
210101	Үндсэн цалин	170,369,000.00	170,010,716.93
210102	Нэмэгдэл	81,777,100.00	75,925,393.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,796,000.00	3,784,000.00
210104	Урамшуулал	29,120,300.00	28,219,273.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,754,400.00	38,754,400.00
210201	Тэтгэврийн даатгал	27,361,700.00	27,361,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,780,600.00	2,780,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,296,800.00	2,296,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,100.00	574,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,741,200.00	5,741,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,407,300.00	13,369,567.00
210301	Гэрэл, цахилгаан	3,407,300.00	3,336,509.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,033,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,585,000.00	13,594,270.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	586,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,585,000.00	11,132,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,732,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	142,150.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	21,712,900.00	16,065,941.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,847,700.00	11,238,250.00
210502	Хоол, хүнс	6,500,000.00	4,827,691.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	365,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,696,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	736,800.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,959,530.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	195,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	195,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,632,200.00	12,287,403.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,632,200.00	12,287,403.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4001600.00	3517000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,001,600.00	3,517,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1200000.00	1200000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	400,855,800.00	383,123,327.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	351,695,900.00	351,695,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	351,695,900.00	351,695,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,407,300.00	18,329,097.00
132001	Орон нутгийн төсвөөс	18,407,300.00	18,329,097.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,752,600.00	13,098,330.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,752,600.00	13,098,330.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	504,032.42
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18
620003	Үйлчлэх ажилтан	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,908,774.00	123,704,781.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,908,774.00	123,704,781.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,908,774.00	98,504,781.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,237.00	37,887,408.00
210101	Үндсэн цалин	61,237.00	37,484,908.00
210102	Нэмэгдэл		402,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,646,073.00
210201	Тэтгэврийн даатгал		4,646,073.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,500.00	439,200.00
210401	Бичиг хэрэг		292,000.00
210402	Тээвэр, шатахуун	88,500.00	147,200.00
2105	Нормативт зардал		44,793,561.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		36,973,830.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс		7,819,731.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,759,037.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,759,037.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,738,529.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,738,529.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	25,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		25,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		25,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,908,774.00	123,836,781.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,908,774.00	123,836,781.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,759,037.00	123,343,981.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,737.00	492,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		132,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, шилэн данс, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг эрхэмлэнэ” гэсэн эрхэм зорилготой байна.

Зорилт: Мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж бүсийн сум дунд эмнэлэг болох зорилтыг дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 5,667.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **91.9** сая төгрөг буюу 30.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		0.6	0.6
Авлага		45.2	45.2
Бараа материал	27.0	28.7	1.7
Үндсэн хөрөнгө	276.5	320.9	44.4
Нийт хөрөнгө	303.5	395.4	91.9
Засгийн газрын оруулсан капитал	287.3	287.3	
Хуримтлагдсан үр дүн		91.9	91.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16.2	16.2	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	303.5	395.4	91.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас коронавируст халдварыг гэрээр үзүүлэх тусламж, хэвтэн эмчлүүлэгчдийн дутуу санхүүжилт 45.2 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.7 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 320.9 сая төгрөг болж 44.4 сая төгрөгөөр өссөн байна. Дээд шатны байгууллагаас өгсөн тоног төхөөрөмжийг бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй

60.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 287.3 сая төгрөг болж, 91.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 252.0 сая төгрөгөөр буюу 63.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, коронавируст халдварыг гэрээр үзүүлэх тусламж, хэвтэн эмчлүүлэгчдийн эмчлүүлсний хөлс, халдварын үед ажилласан ажилчдад олгосон тэтгэмжтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 155.9 сая төгрөг буюу 41.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэл, норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 400.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 400.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд 400.9 сая төгрөгийн төсөв баталснаас 351.7 сая улсын төсвөөс, 18.4 сая орон нутгийн төсвөөс, 30.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 351.7 сая, орон нутгийн төсвөөс 18.3 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 13.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 382.6 сая төгрөгийг зарцуулж, 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382.6 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу санхүүжилт авсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 123.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 0.5 сая төгрөг нийт 123.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшилд 37.9, нийгмийн даатгалын шимтгэлд 4.6, хангамж, бараа материалын зардалд 0.4, норматив зардалд 44.8, бараа үйлчилгээний бусад зардалд 10.5, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 25.2 сая нийт 123.5 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд эрүүл мэндийн даатгалын сангаас 45.2 сая төгрөгийн авлагатай байна. Уг авлагыг 2022 оны 01 сард бүрэн олгосон бөгөөд 2021 оны төсвийн үлдэгдэл 0.6 сая төгрөг байна. Төсвийн болон авлагаас төвлөрсөн төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлан, дээд шатны төсвийн захирагч болон төсөв батлах эрх бүхий байгууллагын шийдвэрээр зарцуулах эрх олгох эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс, хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроосон 8 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

3.9.2.1 Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

3.9.2.2 Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос биелэлт 77.8 хувьтай, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага бүрэн биелүүлж, 2 зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 45.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Ковид-19 цар тахлын үед ард иргэдээс бэлнээр өгсөн 3.5 сая төгрөгийн хандив тусламжийг төсвийн харилцах дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 /Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 /аж ахуйн бүх ажил, гүйлгээ/, Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаал Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-ын 2.6 /Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана./ дахь заалт болон тохиолдсон байх, иж бүрэн байх, тасалбар болголт, толилуулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.1.2 Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 0.6 сая төгрөгөөр төсвөөс илүү шилжүүлж, зардлаар илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн /Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 20 дугаар зүйлийн 20.2.5 /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах/ дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

4.2.1 Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг нүд үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1¹, 72.4.2²,

¹ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

² тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

72.4.4³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6⁴ дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд нэр бүхий 4 ажилчны 1.5 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 14 дүгээр зүйлийн 14.4.6 /бүх зардал/ дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2.3 Бараа материалын тайланд 2.8 сая төгрөгийн эмийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 /санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 /аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;/, 20 дугаар зүйлийн 20.2.4 /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, Сангийн сайдын 388 тоот тушаал ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 86 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна. Энэ нь төсвийн нээлттэй, ил тод, цаг хугацаандаа байх зарчим алдагдаж олон нийт мэдээллээр цаг хугацаандаа мэдээллээр хангагдахгүй байна.

³ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

⁴ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

3. Авлагатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 45.2 сая төгрөгийн авлагатай байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээд шатны төсөв захирагч болон төсөв батлах эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа төсвийн үлдэгдлийг зарцуулахыг зөвлөмж болгож байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв	8	53.6	-	-	2	4.1	3	4.3	3	45.2